



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 21 өдөр

Дугаар A/16

Бор-өндөр сум

Ёс зүйн хэсгийн хорооны бүрэлдэхүүнийг
шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/256 тоот тушаал, 2019 оны А/406 тоот тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эмнэлгийн ёс зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга:	Т.Баярчимэг	Үйл ажиллагаа эрхэлсэн дарга
Нарийн бичиг:	Б.Хэрлэн	Архив, бичиг хэргийн ажилтан
Гишүүд:	Ц.Гантуяа	ХАЯТ-н сувилагч
	Ц.Отгончимэг	Лаборант
	Б.Цэндсүрэн	Эм зүйч

2. Эмнэлгийн ёс зүйн хорооны үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан санал зөвлөмж гаргах чиг үүргийг Ёс зүйн хорооны дарга (Т.Баярчимэг)-т үүрэг болгосугай

3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг хангуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллахыг ёс зүйн багийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА

А.БАТБААТАР

